



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/905

Улаанбаатар хот

“Фармакопей боловсруулах, батлах болон
фармакопейн хорооны ажиллах журмыг боловсруулах
ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын дэд дарга Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн “Ажлаас чөлөөлөх тухай” Б/54 дүгээр тушаалаар чөлөөлөгдсөн тул “Фармакопей боловсруулах, батлах болон фармакопейн хорооны ажиллах журам”-ыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, удирдамжийн дагуу ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын дотоод аудит, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэнд даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/132 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны
10 дугаар сарын 31-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

ФАРМАКОПЕЙ БОЛОВСРУУЛАХ БАТЛАХ БОЛОН
ФАРМАКОПЕЙН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ ШИНЭЧЛЭН
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Д.Бямбадорж (Эм, эмнэлгийн хэрэгслийн
хяналт, зохицуулалтын газрын Эм
үйлдвэрлэлийн хэлтсийн дарга)

Гишүүд:

Ч.Амаржаргал (Эрүүл мэндийн яамны
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын Эм,
эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж
хариуцсан ахлах шинжээч)

Ш.Энхзаяа (Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын Эм шинжлэх
лабораторийн дарга)

С.Цэцэгмаа (ЭМЯ-ны дэргэд дэх Фармакопейн
хорооны гишүүн, Монголын анагаах ухааны
академийн гишүүн, академич, Эм зүйн ухааны
доктор, профессор)

Д.Энхжаргал (ЭМЯ-ны Эм зүй, эм судлалын
мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий
мэргэжилтэн, Эм зүйн ухааны доктор,
профессор)

Ч.Чимэдрагчаа (ЭМЯ-ы Уламжлалт анагаах
ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн
гишүүн, Анагаахын шинжлэх ухааны доктор, дэд
профессор)

Д.Сэлэнгэ (ЭМЯ-ны дэргэд дэх Фармакопейн
хорооны гишүүн, Эрүүл ахуйч, микробиологич,
тэргүүлэх зэргийн эмч)

Х.Даариймаа (ЭМЯ-ны Эм зүй, эм судлалын
мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий гишүүн,
Эм зүйн ухааны доктор, дэд профессор)

Э.Одбаяр (Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт
зохицуулалтын газрын Эмийн үйлдвэрийн
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Э.Баасандорж (Эм, эмнэлгийн хэрэгслийн
хяналт зохицуулалтын газрын Биологийн идэвхт

бүтээгдэхүүн, протез, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Энхзаяа (Монголын Эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбоо ТББ-ын Эм үйлдвэрийн зөвлөлийн дарга)

Нарийн бичгийн дарга:

Б.Хишигжаргал (Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Шинэ эм, инновацийн асуудал хариуцсан мэргэжилтэн)